



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 17 өдөр

Дугаар

А/809

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчөөс төрийн өмчид
эд хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дах заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 75 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Нийслэлийн “Төр захиргааны авто бааз” УТҮГ-ын балансад бүртгэлтэй, хавсралтад заасан, 70,000,000.00 (далан сая) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий тээврийн хэрэгслийг төрийн өмчид шилжүүлсүгэй.

2.Хавсралтад заасан тээврийн хэрэгслийг төрийн өмчид шилжүүлэх ажлыг зохион байгуулж, данс бүртгэлээсээ хасахыг “Төр захиргааны авто бааз” УТҮГ (Э.Болор-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т даалгасгай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



1110203341



НИЙСЛЭЛИЙН ӨМЧӨӨС ТӨРИЙН ӨМЧИД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

№	Эд хөрөнгийн нэр	Марк	Улсын дугаар	Арлын дугаар	Ашигла лтад орсон он	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэх байгуулага	Шилжүүлэн авах байгуулага
1	Тээврийн хэрэгсэл	Фольксваген пассат	06-23 УБӨ	WWWZZZ3CZ GE057883	2015	70,000,000	41,683,306.48	28,316,693.52	Нийслэлийн Төр Захиргааны авто бааз	Хил хамгаалах ерөнхий газар
Нийт дүн						70,000,000	41,683,306.48	28,316,693.52		